



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 4/20

Зуунмод

Өмч хамгаалах байнгын зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит хуулийн эмгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.1.1, 2.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын өмч хөрөнгийг зөв зохистой, ариг гамтай ашиглах, эд хөрөнгийн тооллогын ажилд хяналт тавих, худалдах, устгах эд хөрөнгийн талаар дүгнэлт гаргах, засаж сэлбэх, ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Ахлах нягтлан бодогч

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Н я р а в

2. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам болон ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг тайлагнан, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зөвлөлийн дарга (Ц.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.НАСАНЖАРГАЛ

41230197